



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Төлбөрийн акт	14
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 85

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,782,280.00</u>	<u>61,134,210.00</u>
33	АВЛАГА	282,280.00	744,176.00
335	Бусад авлага	282,280.00	744,176.00
3351	Байгууллагаас авах авлага	282,280.00	744,176.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,500,000.00	60,390,034.00
354	Хангамжийн материал	6,500,000.00	60,390,034.00
35420	Аж ахуйн материал	6,500,000.00	6,500,000.00
35460	Хүнсний материал	00.00	466,018.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	53,424,016.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>318,442,614.59</u>	<u>315,367,575.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	318,442,614.59	315,367,575.01
392	Биет хөрөнгө	310,948,614.59	307,873,575.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	311,985,280.68	311,985,280.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-28,504,200.48	-42,756,300.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,798,214.00	77,298,214.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-60,446,862.28	-70,380,221.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,933,000.00	88,755,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,000,047.71	-60,523,473.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,734,174.00	31,734,174.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-26,936,943.62	-29,625,097.22
39217	Ном	1,386,000.00	1,386,000.00
393	Биет бус хөрөнгө	7,494,000.00	7,494,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,494,000.00	7,494,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>325,224,894.59</u>	<u>376,501,785.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>741,129.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	741,129.00
413	Өглөг	00.00	741,129.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	741,129.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>325,224,894.59</u>	<u>375,760,656.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	325,224,894.59	375,760,656.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,813,370.00	190,813,370.00
51101	Өмч: - төрийн	190,813,370.00	190,813,370.00
512	Хуримтлагдсан үр дүн	61,523,996.14	112,059,757.56
51210	Өмнөх үеийн үр дүн	61,523,996.14	61,523,996.14
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	50,535,761.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,887,528.45	72,887,528.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>325,224,894.59</u>	<u>376,501,785.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	419,099,366.69	491,103,516.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	78,246,016.00

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	00.00	78,246,016.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	78,246,016.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	78,246,016.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,672,500.00	27,506,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391,426,866.69	385,350,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	160,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	160,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,672,500.00	27,346,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,672,500.00	27,346,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	449,103,352.77	440,567,754.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,103,352.77	440,567,754.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,140,835.68	436,467,799.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,111,666.60	292,554,780.00
210101	Үндсэн цалин	180,894,102.95	187,294,714.03
210102	Нэмэгдэл	79,065,415.10	75,677,456.96
210104	Урамшуулал	39,152,148.55	29,582,609.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,817,600.00	38,889,600.00
210201	Тэтгэврийн даатгал	25,716,000.00	27,366,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,025,400.00	2,880,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,420,300.00	2,304,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	605,100.00	576,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,050,800.00	5,761,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,672,500.00	25,087,729.00
210301	Гэрэл, цахилгаан	2,849,173.00	2,483,971.00
210302	Түлш, халаалт	20,762,580.40	22,028,258.00
210303	Цэвэр, бохир ус	1,060,746.60	575,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,881,100.00	1,508,000.00
210401	Бичиг хэрэг	225,300.00	402,600.00
210402	Тээвэр, шатахуун	657,100.00	650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,600.00	116,000.00
210404	Ном, хэвлэл	71,400.00	92,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	825,700.00	246,500.00
2105	Нормативт зардал	39,850,634.00	34,368,862.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,098,020.00	2,802,500.00
210502	Хоол, хүнс	35,886,514.00	29,888,352.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	866,100.00	1,678,010.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,926,889.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,926,889.00
2107	Томилолт, зочны зардал	348,100.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	348,100.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,416,100.00	4,061,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	876,100.00	4,061,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,043,135.08	36,953,339.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,311,000.00	2,663,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,732,135.08	33,397,039.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,962,517.09	4,099,955.00

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	3,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,962,517.09	599,955.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,962,517.09	599,955.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-30,003,986.08	50,535,761.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-30,003,986.08	50,535,761.42

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,813,370.00	72,887,528.45	61,523,996.14	325,224,894.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,813,370.00	72,887,528.45	61,523,996.14	325,224,894.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	50,535,761.42	50,535,761.42
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,813,370.00	72,887,528.45	112,059,757.56	375,760,656.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	419,099,366.69	412,857,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	419,099,366.69	412,857,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391,426,866.69	385,350,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	160,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	160,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,672,500.00	27,346,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,672,500.00	27,346,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	419,099,366.69	407,357,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,099,366.69	407,357,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,136,849.60	403,257,545.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,111,666.60	292,272,500.00
210101	Үндсэн цалин	180,894,102.95	187,012,434.03
210102	Нэмэгдэл	79,065,414.65	75,677,456.96
210104	Урамшуулал	39,152,149.00	29,582,609.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,817,600.00	38,889,600.00
210201	Тэтгэврийн даатгал	25,716,000.00	27,366,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,025,400.00	2,880,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,420,300.00	2,304,500.00

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	605,100.00	576,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,050,800.00	5,761,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,672,500.00	24,346,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,849,173.00	2,483,971.00
210302	Түлш, халаалт	20,762,580.40	21,287,129.00
210303	Цэвэр, бохир ус	1,060,746.60	575,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,881,100.00	1,508,000.00
210401	Бичиг хэрэг	225,300.00	402,600.00
210402	Тээвэр, шатахуун	657,100.00	650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,600.00	116,000.00
210404	Ном, хэвлэл	71,400.00	92,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	825,700.00	246,500.00
2105	Нормативт зардал	39,578,783.00	35,505,945.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,098,020.00	2,802,500.00
210502	Хоол, хүнс	35,614,663.00	30,969,145.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	866,100.00	1,734,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	348,100.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	348,100.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,416,100.00	4,061,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	876,100.00	4,061,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,311,000.00	3,556,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,311,000.00	2,663,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,962,517.09	4,099,955.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	3,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,962,517.09	599,955.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,962,517.09	599,955.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412,697,500.00	412,097,545.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,697,500.00	412,097,545.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,197,500.00	408,597,545.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,272,500.00	292,272,500.00
210101	Үндсэн цалин	214,675,100.00	187,012,434.03
210102	Нэмэгдэл	44,707,700.00	75,677,456.96
210104	Урамшуулал	32,889,700.00	29,582,609.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,889,600.00	38,889,600.00
210201	Тэтгэврийн даатгал	27,366,800.00	27,366,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,880,800.00	2,880,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,304,500.00	2,304,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	576,100.00	576,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,761,400.00	5,761,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,346,600.00	24,346,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,738,100.00	2,483,971.00
210302	Түлш, халаалт	20,299,100.00	21,287,129.00
210303	Цэвэр, бохир ус	1,309,400.00	575,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,508,000.00	1,508,000.00
210401	Бичиг хэрэг	402,600.00	402,600.00
210402	Тээвэр, шатахуун	650,000.00	650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,800.00	116,000.00
210404	Ном, хэвлэл	92,900.00	92,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	227,700.00	246,500.00
2105	Нормативт зардал	35,897,200.00	35,345,945.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,642,500.00	2,642,500.00
210502	Хоол, хүнс	31,520,400.00	30,969,145.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,734,300.00	1,734,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	8,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	5,500,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилот, зочны зардал	117,000.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	117,000.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,110,300.00	4,061,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,110,300.00	4,061,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3556300.00	3556300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,663,300.00	2,663,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3500000.00	3500000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	3,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,500,000.00	3,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	412,697,500.00	412,097,545.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	385,350,900.00	384,750,945.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,350,900.00	384,750,945.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,346,600.00	27,346,600.00

132001	Орон нутгийн төсвөөс	27,346,600.00	27,346,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,000.00
2105	Нормативт зардал	160,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр болон шилэн данстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг нь “Бид хүүхэд нэг бүрийн хөгжил хэрэгцээ сонирхолд нь тулгуурлан ажиллана.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 449.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Нийт зардал өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буурсан тул материаллаг байдлыг 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 5.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,277.0 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	282.3	744.2	461.9
Бараа материал	6,500.0	60,390.0	53,890.0
Үндсэн хөрөнгө	318,442.6	315,367.6	- 3,075.0
Нийт хөрөнгө	325,224.9	376,501.8	51,276.9
Богино хугацаат өр төлбөр	-	741.1	741.1
Засгийн газрын хувь оролцоо	325,224.9	375,760.7	50,535.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	325,224.9	376,501.8	51,276.9

Бараа материалын дансны үлдэгдэл 53,890.0 мянган төгрөгөөр өсөхөд тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 53,424.0 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом авсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 72,004.1 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал тайлант онд 53,424.0 мянган төгрөгийн бараа материал, 24,822.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,535.6 мянган төгрөгөөр буурч, тайлант онд 440,567.8 мянган төгрөг болсон байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хоол, хүнсний зардал байна. Тодруулбал өмнөх оноос хоол, хүнсний зардал 5,998.2 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 446,129.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 446,129.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12,516.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 458,646.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсөв 45,948.9 мянган төгрөгөөр хасагдаж, 412,697.5 мянган төгрөгөөр батлагдсан байна. Төсвийн тодотголоор төсөв хасагдсан боловч тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлэх 27 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 97.8 хувьтай хэрэгжсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 412,697.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 385,350.9 мянган төгрөгийг улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх, 27,346.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 412,697.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 412,097.5 мянган төгрөгийг зарцуулж, 600.0 мянган төгрөгийг улсын төсөвт төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 412,097.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хоол, хүнсний зардал 551.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 160.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 160.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага бөгөөд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5.1-д заасан 4 зорилтыг хэрэгжүүлж ажилладаг байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 27 арга хэмжээний хэрэгжилт 97.8 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.9 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн

дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан 17.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 744.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, шилэн данстай холбоотой 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант оны эцэст 744.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагын үлдэгдэлтэй буюу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7, 45.2 дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 46 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд ХХОАТ-ын 744.2 мянган төгрөгийн авлагатай, өглөг тусгагдаагүй байхад татварын байгууллагын тодорхойлолтоор суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 2,476.8 мянган төгрөгийн илүү, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 2,081.2 мянган төгрөгийн илүү, газрын төлбөр 24.0 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагын тодорхойлолт дахь татварын илүү, дутуу төлөлтийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд санхүүжилтийг мэдээлээгүй, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-тай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын

2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг	3	0.7	0	0	1	0.7	0	0	2	0
Дүн		3	0.7	0	0	1	0.7	0	0	2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг	1	0	0	0	0	0	0	0	1	0
Дүн		1	0	0	0	0	0	0	0	1	0
Нийт дүн		4	0.7	0	0	1	0.7	0	0	3	0